БАТЛАВ.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ш.МӨНХЦЭРЭН

# Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамнаас Авлигатай тэмцэх чиглэлээр 2010 онд хийх үйл ажиллагааны төлөвлөгөө

| № | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | | | | Хариуцах эзэн, хамтран ажиллах байгууллага | Хүрэх үр дүн | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Нөөц | | Хугацаа | Гүйцэтгэлийн үзүүлэлт | | | |
| | | | Хүн хүчний | Хөрөнгө санхүүгийн | | | | | |
| **Тулгуур 1. Ёс зүйтэй манлайлал** | | | | | | | | | |
| 1 | Авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёсыг тогтоох | Сайд, дарга нар авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлээ илэрхийлж авлигыг үл тэвчих, ёс зүй, шударга ёсыг эрхэмлэх талаар олон нийтэд мэдэгдэл хийх | Хүн/өдөр | Шаардаг-дахгүй | II улирал | • Мэдэгдэл хийсэн байх<br>• Олон нийтэд хүрсэн байх | Сайд | Байгууллагын ажилтнууд болон олон нийтэд шударгаар ажиллаж, амьдрах итгэл үнэмшил бий болно. | |
| | | Төсвийн тогтмол хувийг авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах | Хүн/өдөр | 3000.000 | Жилдээ | • Шаардагдах хөрөнгийг ТЕЗ-ийн төсвийн багцад суулгах саналыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлсэн байх<br>• Батлагдсан төсвийг зарцуулж ажилласан байх<br>• Байгууллын төсөвт хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр тусгасан зардлын тодорхой хувийг энэ чиглэлд зарцуулсан байх<br>• | ТНБД | | |
| | | Авлигатай тэмцэх ажлыг сурталчлан таниулах самбар ажиллуулах | | | | | | | |
| | | Сонирхлын зөрчлийг мэдүүлэх тогтолцоог нэвтрүүлэх | Багаар | + | Хууль батлагд-саны дараа | • Хуульд нийцсэн байх<br>• Хуулийн хэрэгжилтийг хангасан байх | Нэгжийн дарга нар | | |
| **Тулгуур 2. Хувь хүний шударга байдал** | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны албан хаагчдын ёс зүйн дүрмийг боловсруулан батлуулах | Багаар | - | II улирал | • Төслийг ажилтнуудад танилцуулж, санал солилцсон байх<br>• АТГ-аас санал авсан байх<br>• Батлагдсан байх | Н.Зургаанжин<br>Ш.Энхбаатар | | |
| 2 | Шударга ёс, эрхэмлэх зүйлс болон ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны албан хаагчийн "Ёс зүйн дүрэм"-ийг нийт албан хаагчдад сурталчлан таниулах, мөрдүүлэх | Багаар | - | II улирал | • Нийт ажилтнуудад хүргэсэн байх | Н.Зургаанжин | Хувь хүний шударга байдал, ёс зүйд ахиц гарсан байх | |
| | | 2010 оны 1 дүгээр сараас төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт болон үр дүнгийн гэрээнд шударга ёсны шалгуур, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар тодорхой заалт оруулах, гэрээг дүгнэх нэг шалгуур үзүүлэлт болгох бэлтгэл ажлыг хангах. | Хүн/өдөр | | I улирал | • Байгууллагын онцлогт тохирсон байх<br>• Ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд өөрчлөлт орсон байх<br>• Дүгнэх шалгуур үзүүлэлт тодорхой болсон байх<br>• Шалгуур үзүүлэлтийг баримтлан Үр дүнгийн гэрээг дүгнэсэн байх | Бүх газар, хэлтсийн дарга нар | | |
| 3 | Ажилтнуудын ёс зүйг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх талаар сургалт, семинар зохион байгуулах | "Байгууллагын соёл" сэдвээр хичээл заалгах | 3 хүн өдөр | 700.000 | II, IV улирал | • Албан хаагчид сургалт, сурталчилгаанд бүрэн хамрагдсан байх<br>• Сургалт давтамжтай байх<br>• Сургалт үр дүнгээ өгсөн байх | ТЗУГ<br>АТГ<br>ТАЗ<br>Удирдлагын академи | | |
| | | "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр сургалт явуулах | 3 хүн өдөр | | | | | | |
| | | "Ашиг сонирхолын зөрчил" сэдвээр сургалт явуулах | 3 хүн өдөр | | | | | | |
| | | Авлигатай тэмцэх хууль, тогтоомжийг сурталчлах | 3 хүн өдөр | | | | | | |
| **Тулгуур 3. Тогтолцооны шударга байдал** | | | | | | | | | |
| 4 | Авлига үүсгэж болзошгүй дүрэм журмыг хянах, шаардлагатай бол хүчингүй болгох | Төрийн байгууллагад мөрдөгдөж буй хүнд суртал, чирэгдэл учруулсан дүрэм, журмыг нягтлан үзэж, шаардлагатай тохиолдолд хүчингүй болгох ажлыг зохион байгуулах чиглэлээр ажлын хэсэг байгуулж ажиллах | Багаар | + | Жилдээ | • Зохион байгуулалтын бүтцийн нэгжийн төлөөллийг хамруулсан байх<br>• Тодорхой санал дүгнэлт гаргаж, хэрэгжүүлсэн байх | Б.Алтанжаргал<br>Ш.Энхбаатар | Тогтолцооны шударга байдал хангагдана. | |
| | | Төрийн зарим үйлчилгээг | Багаар | | Жилдээ | • Гомдол, мэдээллийн сан бүрдүүлсэн байх | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | цахим хэлбэрээр явуулах талаар судлах, | | | | • Гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийн хугацаа шуурхай болгосон байх | Х.Цолмон Ц.СүхбаатарБ. Алтанцэцэг | | |
| | | Авлигад өртөх эрсдэлтэй ажил, үйлчилгээг тодорхойлох | Багаар | - | Тухай бүр | • Эрсдэлтэй ажил үйл-чилгээний жагсаалтыг гаргасан байх | ТЗУГ СХОХ | | |
| | | Бараа ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээний үүргээ биелүүлээгүй нь нотлогдсон иргэн, хуулийн этгээдийг хар жагсаалтад бүртгэж, нийтэд мэдээлэх | Багаар | | Жилдээ | • Хар жагсаалтыг гаргаж, бүртгэл хөтөлсөн байх<br>• Нийтэд мэдээлсэн байх | СХОХ | | |
| | | Тендрьтэй холбоотой гэрээ, хэлэлцээрт авлигын эсрэг заалт оруулах | Хүн/өдөр | | Жилдээ | • Хуульд нийцсэн байх<br>• Авлигын эсрэг заалт оруулсан байх | Ерөнхий менежер Хуулийн зөвлөх, | | |
| 5 | Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах | Үйл ажиллагааны ил тод, нээлтэй байдлыг хангах | Багаар, | - | Жилдээ | • Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолд заасан үзүүлэлтийг хангасан байх | МХШҮГ ТЗУГ СХОХ | Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт хангагдана. | |
| | | Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангах | 50 хүн өдөр | | | | | | |
| | | Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах | 10 хүн өдөр | | | | | | |
| | | Боловсон хүчнийг сэлгэн ажиллуулах арга хэмжээ авах | багаар | | Жилдээ | • Ажлын байрны судалгаа явуулсан байх<br>• Сэлгэн ажиллуулсан байх | | | |
| **Тулгуур 4. Хяналт шинжилгээ болон таслан зогсоох** | | | | | | | | | |
| 6 | Авлигын эсрэг хууль тогтоомж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах | Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, туслалцаа үзүүлэх багийг бий болгон ажиллах /Иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулах/ | Багаар | - | Жилдээ | • Баг бүрдүүлсэн байх<br>• Цаашид хэрэгжүүлэх ажилд зөвлөмж, туслалцаа өгсөн байх | ТЗУГ | Хариуцлагын тогтолцоо бий болно. | |
| | | Авлигын эсрэг хууль тогтоомж, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, АТГ-т хүргүүлэх | Хүн/өдөр | - | 4, 7,10, 1 сард | • Хууль тогтоомж болон төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ хэрэгжсэн байх<br>• Тодорхой ажилтан, албан тушаалтанд хариуцуулж, | ТЗУГ | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлын байрны тодорхойлолтод тусгасан байх<br>• Тайлан, мэдээ хуга-цаандаа хүргэгдсэн байх | | | |
| | | Албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой аливаа асуудлыг АТГ-т мэдээлэх | Хүн/өдөр | - | Тухай бүр | • АТГ-т нэн даруй мэдэгдсэн байх | Албан тушаалтан, ажилтан | | |
| | | Гомдол мэдээлэл хүлээн авах тусгай утас /хайрцаг, дэвтэр/ ажиллуулж, мэдээллийн мөрөөр тодорхой арга хэмжээ авах | Багаар | + | Жилдээ | • Гомдол, мэдээллийн мөрөөр тодорхой арга хэмжээ зохион байгуулсан байх<br>• Мэдээлэгч болон мэ-дээллийн нууцлалыг хангах талаар баталгаа авсан байх, задруулсан тохиолдолд хариуцлага хүлээдэг тогтолцоонд шилжсэн байх | ТЗУГ | | |
| | | Өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх ажлыг хариуцсан дотоод хяналтын багийг ажиллуулах | Багаар | | III улирал | • Холбогдох журамд өөрчлөлт оруулсан байх<br>• Шат дамжлага багассан байх | Хуулийн зөвлөх, | | |

**Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам**